



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/468

Ховд

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр заалтын 8.30 дахь заалт, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, 14.7 дахь хэсэг, Ховд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 6/07 дугаар тогтоол, Ашигт малтмал газрын тосны газрын газрын Кадастрын хэлтсийн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Ховд сумын Хатуу хөтөл нэртэй 26,16 га талбайд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийх тусгай зөвшөөрлийг "Нью минерал" ХХК-д 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон талбайн солбицлыг хавсралтаар баталсугай.

3. Холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг "Нью минерал" ХХК-д үүрэг болгосугай.

4. Тусгай зөвшөөрөл олгосон аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллахыг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Цогзолмаа), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Төгөлдөр), Ховд сумын Засаг дарга (Я.Өмирхан), Уул уурхайн хяналтын улсын байцаагч (Н.Алтанцэцэг) нарт даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х.БАТБОЛД

8400001 1156

Zah A/468 Ba

Засаг даргын 2024 оны
07-дугаар сарын 02-ны өдрийн
А/468 дугаар захирамжийн хавсралт

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ХАЙГУУЛЫН
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН ТАЛБАЙН СОЛБИЦОЛ

№	У	Х
1	2	3
1	91° 37' 33.6"	48° 05' 46.32"
2	91° 37' 33.6"	48° 06' 0.72"
3	91° 37' 5.16"	48° 06' 0.72"
4	91° 37' 5.16"	48° 05' 46.32"

-oOo-